



I-VI/2021


Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 17



Статистикийн бизнес регистрийн сан

Статистикийн бизнес регистр (СБР)-ийн санд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 210.9 мянган хуулийн этгээд бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 15.0 мянга буюу 7.7 хувь, өмнөх оны эцсээс 10.4 мянга буюу 5.2 хувь, өмнөх улирлаас 5.1 мянга буюу 2.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 1. Хуулийн этгээдийн тоо, хариуцлагын хэлбэрээр, 2021 оны эхний хагас жилийн байдлаар




Хуулийн этгээдийн 167.4 мянга буюу 79.4 хувь нь компани, 27.1 мянга буюу 12.8 хувь нь төрийн бус байгууллага, 4.8 мянга буюу 2.3 хувь нь төсвийн байгууллага, 5.1 мянга буюу 2.4 хувь нь нөхөрлөл, 4.5 мянга буюу 2.1 хувь нь хоршоо байна.


Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн 160.4 мянга буюу 76.0 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 17.8 мянга буюу 8.4 хувь нь Төвийн бүсэд, 15.5 мянга буюу 7.3 хувь нь Хангайн бүсэд, 11.3 мянга буюу 5.4 хувь нь Баруун бүсэд, 6.0 мянга буюу 2.8 хувь нь Зүүн бүсэд бүртгэлтэй байна.

Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймагт 3.8-5.2 мянган хуулийн этгээд бүртгэлтэй байгаа бол Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар, Говь-Алтай аймагт бүртгэлтэй хуулийн этгээдийн тоо 0.6-1.3 мянга байна.

Зураг 2. Хуулийн этгээд, байршлаар, 2021 оны эхний хагас жилийн байдлаар



Зураг 3. Хуулийн этгээдийн тоо, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, улирлаар




Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 210.9 мянган хуулийн этгээдийн 44.4 хувь нь үйл ажиллагаа явуулж, 55.6 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 63.1 мянга буюу 53.8 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй бол үлдсэн 46.2 хувь нь бусад шалтгаантай байна. Үйл ажиллагаа эхлээгүй хуулийн этгээдийн эзлэх хувь 1.3 функтээр өссөн байна.

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн тоо, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, улирлын эцэст


Хугацаа	Бүгд	үйл ажиллагаа явуулж байгаа		үйл ажиллагаа явуулаагүй	эхлээгүй	түр зогсоосон	бүрэн зогсоосон	бусад (хаяг тодорхой бус, олдохгүй г.м)
		үйл ажиллагаа явуулж байгаа	үйл ажиллагаа явуулаагүй					
2017	I-III	145 092	73 264	71 828	33 048	34 654	1 532	2 594
	I-VI	147 775	75 808	71 967	33 673	34 207	1 515	2 572
	I-IX	150 283	77 097	73 186	35 117	33 999	1 518	2 552
	I-XII	155 077	78 597	76 480	38 149	34 204	1 570	2 557
2018	I-III	158 782	81 030	77 752	40 459	33 212	1 569	2 512
	I-VI	163 112	83 098	80 014	42 618	33 177	1 625	2 594
	I-IX	167 135	85 500	81 635	42 045	35 184	1 815	2 591
	I-XII	170 178	85 761	84 417	44 483	35 457	1 876	2 601
2019	I-III	174 974	87 754	87 220	47 133	35 480	2 012	2 595
	I-VI	177 857	88 893	88 964	48 809	35 428	2 106	2 621
	I-IX	184 314	93 459	90 855	50 684	35 430	2 115	2 626
	I-XII	187 783	94 425	93 358	52 045	36 272	2 475	2 566
2020	I-III	190 830	94 942	95 888	54 308	36 426	2 622	2 532
	I-VI	195 905	96 388	99 517	57 799	36 513	2 678	2 527
	I-IX	199 271	97 248	102 023	60 242	36 522	2 686	2 573
	I-XII	200 451	94 491	105 960	59 265	41 421	3 068	2 206
2021	I-III	205 754	91 685	114 069	59 918	47 051	4 758	2 342
	I-VI	210 893	93 560	117 333	63 117	47 039	4 826	2 351

Үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийг ажиллагчдын тооны бүлгээр авч үзэхэд 1-9 ажиллагчидтай хуулийн этгээд 87.6 хувь, 10-19 ажиллагчидтай хуулийн этгээд 5.3 хувь, 20-49 ажиллагчидтай хуулийн этгээд 4.3 хувь, 50 ба түүнээс дээш ажиллагчидтай хуулийн этгээд 2.8 хувийг эзэлж байна. 1-9 ажиллагчидтай хуулийн этгээдийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр буурсан байна.

Зураг 4. Үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн ажиллагчдын тооны бүлэгт эзлэх хувь, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Зураг 5. Үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Үйл ажиллагаа 2021 оны эхний хагас жилд үйл ажиллагаа явуулсан нийт хуулийн этгээдийн 75.5 мянга буюу 80.7 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарынх байна.

Өмнөх оны мөн үеэс 2021 оны эхний хагас жилд үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн тоо уул уурхай, олборлолтын салбар 17.4 хувиар, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарынх 15.4 хувиар, боловсруулах салбарынх 11.3 хувиар, санхүү болон даатгалын салбарынх 9.4 хувиар тус тус буурсан байна.

Аргачлал

Статистикийн бизнес регистр нь тодорхой бүтэцтэй, тогтмол шинэчлэгдэн статистикийн зорилгоор ашиглагддаг аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл юм.

Статистикийн бизнес регистрийн санд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжүүдийн статистикийн мэдээллийг хамруулна.

Статистикийн бизнес регистрийн мэдээллийн санг аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны анхны тооллогын дүнд үндэслэн байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагын 2006, 2011, 2016 оны тооллогын дүн, мэдээллийн бусад эх үүсвэрээс тогтмол шинэчлэн баяжуулж байна.



Тайлбар: Бизнес регистрийн улирлын мэдээ

Эх үүсвэр: ҮСХ, УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэл, Татварын ерөнхий газар

Ангилал, код: Эдийн засгийн үйл бүх төрлийн ажиллагааны салбарын ангилал-4.0

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга

Э.Эрдэнэсан

Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын

статистикч Ц.Амаржаргал

Утас : (976-51)-261567

